

ДОРНОД АЙМГИЙН ЭМНЭЛГИЙН АЖИЛЧДЫН ДУНД НОЙРНЫ ЧАНАР БОЛОН АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ҮНЭЛСЭН НЬ

Ч.Гэрлээ^{1,2} Ю Шуан Чэн²

¹Дорнод аймаг, Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төв

²Төв Тайваны Шинжлэх Ухааны Их Сургууль,
Биотехнологи болон Эмнэлгийн лабораторийн шинжлэх ухааны тэнхим

ХУРААНГУЙ

Нойрны чанар болон амьдралын чанар нь эрүүл ба өвчин эмгэгтэй хүнд аль алинд нь чухал. Амьдралын чанар болон нойрны чанар муу байх нь ажил мэргэжлийн алдаа гаргахад хүргэхээс гадна амьдралд олон сөрөг нөлөө үзүүлдэг.

Дорнод аймгийн Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төв (БОЭТ)-ийн ажилчдын бие, сэтгэл зүйн эрүүл мэндийн байдлыг асуумжаар үнэлж нойрны чанар болон амьдралын чанарыг тодорхойлох зорилгоор энэ судалгааг хийсэн. Судалгаанд эмч, сувилагч, эм зүйч, захиргааны болон туслах ажилчдаас бүрдсэн 200 хүн оролцсон. Нойрны чанар болон амьдралын чанарыг судлахад PSQI, ESS, SF-39 гэсэн асуумжуудын монгол хувилбарыг ашигласан. Судалгааны үр дүнг авч үзвэл нойрны чанар эмэгтэйчүүдэд (ПНЧИ=6.2±3.4) эрэгтэйчүүдээс (ПНЧИ=4.1±2.6) илүү муу байгаа нь тодорхойлогдов. Нийт оролцогчдод ЭНҮ асуумжийн оноо хэвийн байсан нь өдрийн цагийн нойрмоглолт үгүй гэдгийг илэрхийлж байна. Мөн нийт оролцогчдод ЭМСТМ-36 асуумжийн үнэлгээ болох сэтгэл зүйн эрүүл мэнд (47.4±10.0) болон бие махбодийн эрүүл мэндийн (46.0±8.4) оноо хэвийн хэмжээнээс доогуур байна. Ялангуяа ээлжийн ажилчдад бие махбодийн эрүүл мэнд (45.3±8.4) болон сэтгэл зүйн эрүүл мэндийн (46.9±10.0) үнэлгээ илүү муу байсан. Нойрны чанар сайн бүлэгт бие махбодийн эрүүл мэнд болон сэтгэл зүйн эрүүл мэндийн оноо илүү өндөр байсан бөгөөд ялангуяа сэтгэл зүйн эрүүл мэндийн оноо ач холбогдол бүхий ($p=0.004$) өндөр байв. Бидний судалгаа эмнэлгийн ажилчдын нойрны чанар, амьдралын чанар аль аль нь муу байгааг илрүүлсэн бөгөөд энэ нь эмнэлгийн ажилчид эрүүл мэндийн асуудалтай байна гэдгийг харуулж байна.